



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 сарын 29 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 1, 5, 6, 12 дахь заалт тус тус нэмсүгэй:

“1/Эдийн засаг, хөгжлийн яам;

5/Байгаль орчин, аялал жуулчлалын яам;

6/Батлан хамгаалах яам;

12/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3, 4, 5, 8, 9, 10, 11, 12 дахь заалтын дугаарыг “2, 3, 4, 7, 8, 9, 10, 11” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1, 2, 6, 7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР